



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/08/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор Утас 99026016	Б.Цэвэлмаа Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn
	Аудитор Утас: 85151215	М.Дөлгөөнбаяр Цахим хаяг: dulguunbayarkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	212,161.10	169,474.36
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	866,947.58	972,860.46
	Нийт хөрөнгийн дүн	1,079,108.68	1,142,334.82
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,079,108.68	1,142,334.82
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,079,108.68	1,142,334.82
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	481,746.79	698,279.28
	Үйл ажиллагааны зардлын дүн	527,087.76	635,053.15
	Үйл ажиллагааны үр дүн	-45,340.97	63,226.13
	Үйл ажиллагааны бус үр дүн	4,106.66	0.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-49,447.63	63,226.13
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,128,556.31	1,079,108.68
	Тайлант оны үр дүн	-49,447.63	63,226.14
	Эцсийн үлдэгдэл	1,079,108.68	1,142,334.82
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	408,774.24	548,076.41
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	383,116.00	506,697.41
	Үйл ажиллагааны ЦМГ	25,658.24	41,379.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-25,710.00	-41,379.00
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	338,100.00	446,895.30
	Урсгал зардал	338,100.00	446,895.30
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	338,100.00	446,895.30
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,100.00	446,895.30
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 67.3 сая төгрөгийн алдаа¹, зөрчлийг арилгасан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Зардлын эдийн засгийн ангиллыг 17.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг 8.7 сая

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Төсвийн гүйцэтгэл төсвийн хэлбэлзлээс 12.5 сая төгрөгөөр зөрүүтэй, Бараа материалын тодруулга тайланд 2.5 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 26.0 сая төгрөгийн хөрөнгийг зөрүүтэй тайлагнасан нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалт "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 13.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 заалт 11.0 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс тэмцээн уралдааны шагналд 0.4 сая төгрөг, нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулахад 2.5 сая төгрөг нийт 2.9 сая төгрөгийн зарцуулсан нь "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 5.4.-т " бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" гэж заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс малчдын зөвлөгөөн 5.1 сая төгрөг, тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн 2.0 сая төгрөг, сумын аварга малчдын шагналд 1.8 сая төгрөг, сумын хүндэт иргэний өргөмжлөлд 0.1 сая төгрөг нийт 9.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Засгийн газрын 2021

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Бараа материалын дансанд бүртгэлтэй 31 толгой мал гэрээгүй, гэрээгээр олгосон малын тоо толгой, нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй, 50 толгой 2.0 сая төгрөгийн малын гэрээний хугацаа дууссан, дараагийн айлд шилжүүлээгүй нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Сахилгын хариуцлага тооцуулах тухай албан шаардлага

- ✓ Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/86 дугаартай төлбөрийн актыг барагдуулаагүй, 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/101 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах; Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 214,581.3 мянган төгрөгийн 11 мэдээллийг мэдээлээгүй нь "Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах

Илрүүлэлт: Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшин ашиглаж байгаа авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бугат сумын Засаг даргын Тамгын газар	4	67.30	0	0.00	0.00	0.00	4	67.30	-	-	-	-
Дүн	4	67.30	0	0.00	0	0.00	4	67.30	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Бугат сумын Засаг даргын Тамгын газар	6	13.9	2	2.9	2	11.0	1	-	1	1	-	-
Дүн	6	13.9	2	2.9	2	11.0	1	-	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн						
Говь-Алтай аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газар	2	-	-	-	-	-	2	-
Нийт дүн	2	-	-	-	-	-	2	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-